

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**Санамж:**

- a. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
b. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Чулуун зэвсгийн үеийг ерөнхий байдлаар хэрхэн үечилдэг вэ? **(2 оноо)**
- A. Доод, дунд, дээд шат
B. Эртний, дунд, шинэ үе
C. Бага, дунд, их шат
D. Палеолит, Мезолит, Неолит
E. Чулуун зэвсгийн үе, хүрэл төмрийн түрүү үе
2. Монгол нутагт 800.000 жилийн тэртээ хүн оршин амьдарч байсныг илтгэх түүхийн дурсгал аль нь вэ? **(2 оноо)**
- A. Баянхонгор аймгийн Баянлиг сум Цагаан агуй
B. Ховд аймгийн Манхан сум Ишгэн толгой
C. Дундговь аймгийн Гурвансайхан сум Ярх уул
D. Дорнод аймгийн Булган сум Норовлин уул
E. Ховд аймгийн Алтай сум Барлагийн гол
3. Дараах дурсгалаас Мезолитийн үед холбогдох хадны зураг аль нь вэ? **(2 оноо)**
- A. Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвшийн хадны зураг
B. Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн агуйн зураг
C. Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгойн хадны зураг
D. Ховд аймгийн Чандмань сумын нутаг Чандмань хар үзүүрийн хадны зураг
E. Увс аймгийн Сагил сумын нутагт орших Можоогийн хадны зураг
4. Дор дурьдсан дурсгалуудаас аль нь Энеолит (Зэс чулуу)-ийн үед хамаарах вэ? **(1 оноо)**
- A. Ховд аймгийн Манхан сумын нутаг Цэнхэрийн гол
B. Дорнод аймгийн Тамсагбулагийн суурин
C. Өмнөговь аймгийн Манлай сумын Говийн төхөм
D. Говь-Алтай аймгийн Сүүжийн хөндий
E. Ховд аймгийн Алтай сумын Барлагийн гол
5. Дөрвөлжин булшны соёл Монгол улсын нутгийн аль хэсгээр илүү тархсан байдаг вэ? **(2 оноо)**
- A. Монгол орны төв болон баруун хэсгээр
B. Монгол орны төв болон дорнод хэсгээр
C. Монгол орны төв болон умард хэсгээр
D. Монгол орны баруун болон өмнө хэсгээр
E. Монгол орны төв болон өмнө бүсээр
6. Гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг бүхий хадны зураг хаана байдаг вэ? **(1 оноо)**
- A. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Цамбагарав
B. Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгой
C. Ховд аймгийн Чандмань сумын Чандмань хар үзүүр
D. Ховд аймгийн Үенч сумын Ямаан ус
E. Увс аймгийн Сагил сумын Можоо



7. Монгол нутагт оршиж байсан анхны төрт улс Хүннү гүрэн хэдэн онд Умард, Өмнөд хэмээн задарсан бэ? **(1 оноо)**

- A. НТ 93 он B. НТӨ 198 он C. НТӨ 209 он D. НТ 189 он E. НТ 48 он

8. Жи Жи шаньюй тэргүүлэн баруун зүг нүүсэн Хүннү нар түүхэнд хэрхэн бичигдсэн бэ? **(1 оноо)**

- A. Цагаан Хүннү B. Өмнөд Хүннү C. Умард Хүннү
D. Авар E. Баруун Хүннү

9. Сяньби улсын хаан Тяньшихуайн гарал угсааг хаанаас гаралтай хэмээн домоглон өгүүлдэг вэ? **(1 оноо)**

- A. Язгууртан гаралтай B. Бурхны хүү
C. Харц гаралтай D. Тэнгэр язгуурт E. Тэнгэрийн элч

10. Жужан улсын хаадын дээд өвөг “Мухар толгойт” хэмээн түүхэнд бичигдсэн хаан аль нь вэ? **(1 оноо)**

- A. Амгай B. Шэлүнь C. Тяньшихуай D. Кэбэнин E. Мугулюй

11. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Улаанбаатар хотын Налайх дүүргийн ойр байдаг Түрэг улсын үед холбогдох түүхийн дурсгал гэвэл аль нь вэ? **(1 оноо)**

- A. Мөнх хааны гэрэлт хөшөө B. Долоодойн гэрэлт хөшөө
C. Моюунчурын гэрэлт хөшөө D. Тоньюкүкийн гэрэлт хөшөө
E. Культегины гэрэлт хөшөө

12. Булган аймгийн Сайхан сумын нутаг Могойн шинэ ус хэмээх газарт буй гэрэлт хөшөөг аль улсын, хэн гэдэг хүнд зориулан босгосон бэ? **(1 оноо)**

- A. Түрэгийн Тоньюкукт B. Түрэгийн хаан Билгэд
C. Түрэгийн хаан Культегинд D. Уйгарын хаан Пейлод
E. Уйгарын хаан Моюунчурт

13. 1125 онд Хар Хятан улсыг байгуулсан зүтгэлтэн аль нь вэ? **(1 оноо)**

- A. Елюй Даши B. Елюй Чу Цай
C. Елюй Ян D. Елюй Лубугу E. Елюй Амбагян

14. Дараах дурсгалууд аль улсын түүхтэй холбогдох вэ? зөв харгалзуулна уу? **(2 оноо)**

1. Луут хот a. Уйгар улс
2. Ордубалык b. Хятан гүрэн
3. Чин толгой балгас c. Хүннү гүрэн

- A. 1-а, 2-б, 3-с B. 1-б, 2-а, 3-с
C. 1-с, 2-а, 3-б D. 1-с, 2-б, 3-а E. 1-б, 2-с, 3-а

15. Монгол нутагт эрхшээн оршиж байсан эртний төрт улсуудаас аль нь Их, Бага бичгийг зохион хэрэглэсэн бэ? **(1 оноо)**

- A. Уйгар улс B. Хятан гүрэн
C. Жужан улс D. Хүннү гүрэн E. Түрэг улс



16. Хятан нар өөрсдийн байгуулсан улсаа хэрхэн өргөмжлөн нэрийдсэн бэ? **(1 оноо)**
- A. Хар Хятан улс
C. Их Ляо гүрэн
D. Их Вэй гүрэн
B. Их Тоба гүрэн
E. Хөх Түрэг улс
17. Монгол нутаг дахь ханлиг, аймгийн холбоодын аль нь Орхон мөрний адаг, Сэлэнгэ мөрний дунд биеэр нутаглаж байсан бэ? **(1 оноо)**
- A. Хонгирад
C. Найман
D. Хэрэйд
B. Гурван Мэргэд
E. Хорь түмэд
18. “Монголын нууц товчоон”-нд Добу мэргэн “Нөхөр шоролгодоо” хэмээн хэнд хэлсэн бэ? Тэр хүн ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? **(2 оноо)**
- A. Малиг Баягуд хүнд хэлсэн, ангийн махнаасаа өгсөн
B. Малиг Баягуд хүнд хэлсэн, хүүгээ өгсөн
C. Урианхай хүнд хэлсэн, хүүгээ өгсөн
D. Урианхай хүнд хэлсэн, ангийн махнаасаа хуваалцсан
E. Жарчиуд хүнд хэлсэн, тулалдсан
19. “Монголын нууц товчоонд”-нд бичсэнээр өөрийн долоон хөвүүдээ байтал Сэнгүм Билэгийн хөвүүн Амбагайг хан суулгахаар гэрээслэсэн зүтгэлтэн аль нь вэ? **(2 оноо)**
- A. Хотула хан
C. Байшинхор догшин
D. Тумбинай Сэцэн
B. Хабул хан
E. Охин Бархаг
20. Чингис хааныг эсэргүүцэгч язгууртнууд Жадаран аймгийн Жамуха сэцнийг онд хэмээх газар Гүр хаанд өргөмжилжээ. Нөхнө үү? **(2 оноо)**
- A. 1199, Эргүнэ мөрөн
C. 1189, Муу өндөр
B. 1202, Хар зүрхэний Хөх нуур
D. 1201, Эргүнэ мөрөн
E. 1179, Буур хээр
21. Чингис хааны дөрвөн хүлэг баатар аль нь вэ? **(2 оноо)**
- A. Чуу Мэргэн, Үсүн Өвгөн, Зэв, Сүбээдэй
C. Сорхон Шар, Борохул, Хар Хирүгэ, Зэлмэ
E. Боорчи, Мухулай, Борохул, Чулуун
B. Зэв, Зэлмэ, Хубилай, Сүбээдэй
D. Боорчи, Сүбээдэй, Борохул, Зэв
22. “Монголын нууц товчоо”-нд бичсэнээр, “... Уулс мэт бие чинь нурж одвол улс олон Монголыг чинь хэн захирах юм бэ?” хэмээн аль аймгийн хэн гэдэг хатан сануулан өгүүлсэн бэ? **(2 оноо)**
- A. Татар аймгийн Есүй хатан
C. Мэргэд аймгийн Хулан хатан
E. Тангуд аймгийн Гүрбэлжингоо хатан
B. Татар аймгийн Есүгэн хатан
D. Хонгирад аймгийн Бөртэ хатан
23. Монголын улс төрийн төвийг шилжүүлсний дараа уугуул Монгол орныг хаан ширээ залгамжлах хан хүүгээр захируулж байсан гэвэл хэрхэн нэрлэж байсан бэ? **(1 оноо)**
- A. Ар Монгол орон
C. Давааны арын орон
D. Умард орон
E. Өрнөд орон
B. Өмнөдөд туслах орон
24. Батын хөвүүн Бэрх Алтан ордны улсыг хэдээс хэдэн оны хооронд захирч байсан бэ? **(1 оноо)**
- A. 1266-1280 он
C. 1257-1266 он
D. 1280-1287 он
B. 1227-1266 он
E. 1242-1252 он



25. Их Юань улсын гол хуулиуд аль нь вэ? **(2 оноо)**
- A. Их Юань улсын нэвтэрхий цааз, Юань гүрний үнэн хууль
 B. Их Юань улсын Их засаг хууль, Их Юань улсын магад хууль
 C. Их Юань улсын Их цааз, Их Юань улсын үнэн хууль
 D. Их Юань улсын Их журам, Юань улсын бүгд хууль
 E. Их Юань улсын нэвтэрхий хууль, Их Юань улсын хууль цаазын бичиг
26. Монголын улсуудыг нийслэл хоттой нь зөв тохируулна уу? **(2 оноо)**
- | | |
|--------------------|------------|
| 1. Юань гүрэн | a. Сарай |
| 2. Алтан ордны улс | b. Дайду |
| 3. Цагадайн улс | c. Алмалык |
| 4. Ил хаант улс | d. Султани |
- A. 1-b, 2-d, 3-с, 4-а. B. 1-b, 2-а, 3-d 4-с.
 C. 1-b, 2-а, 3-с, 4-d. D. 1-b, 2-d, 3-а 4-с. E. 1-b, 2-с, 3-а, 4-d.
27. Билэгт хаан хэмээн алдаршсан, Монголын их хаан аль нь вэ? **(1 оноо)**
- A. Гүнтөмөр хаан B. Төгстөмөр хаан C. Элбэг хаан
 D. Аюушир дара хаан E. Буяншир хаан
28. Тогоон тайш, "... Төр мэдэх сайдаа гадаа суулгана, өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам" хэмээн 1437 онд аль Монголчуудыг хэлсэн бэ? **(2 оноо)**
- A. Халимаг Монгол B. Ойрад Монгол
 C. Хөх нуурын Монгол D. Өвөр Монгол E. Зүүн Монгол
29. Эсэн тайш хаан 1453-1454 оны хооронд төр барьж байсан бол, энэ он цагийг зууны тоололд шилжүүлбэл хэддүгээр зууны аль үе вэ? **(1 оноо)**
- A. XV зууны дунд үе B. XV зууны эхэн үе
 C. XIV зууны дунд үе D. XIV зууны эхэн үе E. XV зууны төгсгөл үе
30. Монголын түүхэн сурвалжид "Эзний уул мэт цагаан гэрийг хадгалсан" хэмээн бичигдсэн, Чингис хааны онгоныг сахих үүрэгтэй зүүн Монголын түмэн аль нь вэ? **(2 оноо)**
- A. Ордос B. Юншээбү
 C. Халх D. Цахар E. Түмэд
31. Батмөнх Даян хааны төр барьж байсан он жилүүдийг түүхэн сурвалжид хэрхэн өгүүлсэн байдаг вэ? **(1 оноо)**
- A. Төвшитгөн тогтоосон үе B. Монголын их амар амгалангийн үе
 C. Гар газар, хөл хөсөр байсан үе D. Айх аюул, өлсөх зовлонгүй үе
 E. Гар ганзганд, хөл дөрөөнд хүрсэн үе
32. 1577 онд Төвдийн шарын шашны тэргүүн Содномжамцыг залж түүнд "Далай лам" цолыг анх өгсөн түүхэн зүтгэлтэн хэн бэ? **(1 оноо)**
- A. Хошуудын Гүүш хан B. Түмэдийн Алтан хан
 C. Халхын Сэцэн хан Шолой D. Түшээт хан Гомбодорж
 E. Өндөр гэгээн Занабазар



33. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам анх ямар нэртэй байсан бэ? **(2 оноо)**

- A. Хүрээ сайдын газар
 B. Монгол Төвдийн хороо
 C. Ховдын Манж сайдын газар
 D. Монгол засгийг эрхлэгч яам
 E. Улиастайн жанжны газар

34. Халх, Ойрадын ноёдын Тарвагатайн Улаан бураад болсон чуулган хэдэн онд болсон бэ? **(1 оноо)**

- A. 1640 он B. 1648 он C. 1686 он D. 1691 он E. 1636 он

35. Манжийн эрхшээлийн үед Дөрвөд хоёр аймаг хаана харьяалагдан захирагдаж байсан бэ? **(2 оноо)**

- A. Хүрээ сайдын газарт
 B. Монгол Төвдийн хэлтэст
 C. Засагт хан аймагт
 D. Ховдын Манж сайдын газарт
 E. Улиастайн жанжны газарт

36. Энэ зурагт Чин гүрний эрүү шүүлтийн алийг нь дүрсэлсэн бэ? **(2 оноо)**

- A. Туйвандах
 B. Шаахайдах
 C. Банздах
 D. Чивчрагадах
 E. Дөнгөлөх



37. Чин гүрний үеийн Монголчуудын аймаг ба түүний чуулганыг зөв харгалзуулна уу? **(2 оноо)**

- | | |
|---------------------|--|
| 1. Засагт хан аймаг | a. Хэрлэн барс хотын чуулган |
| 2. Түшээт хан аймаг | b. Цэцэрлэгийн чуулган |
| 3. Сайн ноён аймаг | c. Богд хан уулын чуулган |
| 4. Сэцэн хан аймаг | d. Заг голын эх Биндэрьяа нуурын чуулган |

- A. 1-a, 2-b, 3-c 4-d. B. 1-d, 2-c, 3-b, 4-a.
 C. 1-d, 2-a, 3-b, 4-c. D. 1-b, 2-d, 3-a 4-c. E. 1-b, 2-c, 3-a, 4-d.

38. 1880 оны Онолтоор удирдуулсан цэргийн бослого хаана гарсан бэ? **(1 оноо)**

- A. Улиастай хот
 B. Ховд хот
 C. Их Хүрээ
 D. Хаалган хот
 E. Хиагт хот

39. Чин гүрний эрх баригчид монголын талаар баримталж байсан бодлогоо XIX зууны сүүлчээс өөрчилж Монголд нэгэн бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ ямар бодлого вэ? **(1 оноо)**

- A. Тэнгэрийн бодлого
 B. Шинэ эргэлтийн бодлого
 C. Илбэн тохинуулах бодлого
 D. Эеэр засах бодлого
 E. Шинэ засгийн бодлого

40. 1911 оны Монголын үндэсний хувьсгалын оюун санааны удирдагч хэн байсан бэ? **(1 оноо)**

- A. Да лам Цэрэнчимэд
 B. Егүзэр хутагт Галсандаш
 C. Манзушир хутагт Цэрэндорж
 D. VIII Богд Жавзандамба
 E. Жалханз хутагт Дамдинбазар



41. Есөн сар үргэлжилж Монгол улсыг автономит эрхтэй болгосон гэрээ гэвэл хэдэн оны ямар гэрээ вэ? **(2 оноо)**

- A. 1912 оны Монгол – Орос хоёр улсын гэрээ
- B. 1915 оны Орос, Монгол, Дундад иргэн гурван улсын гэрээ
- C. 1913 оны Орос – Дундад хоёр улсын гэрээ
- D. 1919 оны Дундад – Монгол хоёр улсын гэрээ
- E. 1907 оны Орос – Япон хоёр улсын гэрээ

42. “Нийслэл хүрээний сонин бичиг”, “Шинэ толь” сэтгүүл зэргийг эрхлэн гаргаж байсан эрдэмтэн аль нь вэ? **(1 оноо)**

- A. Ж.Цэвээн
- B. Н.Магсаржав
- C. Ч.Дандаа
- D. О.Жамьян
- E. Л.Дэндэв

43. Богд хаант Монгол улсад дараах бүс нутгийн аль нь багтаж чадаагүй вэ? **(2 оноо)**

- A. Халхын Түшээт хан аймаг, Халхын Засагт хан аймаг
- B. Халхын Сайн ноён аймаг, Халхын Сэцэн хан аймаг
- C. Дөрвөдийн Далай хан аймаг
- D. Дөрвөдийн Үнэн зоригт хан аймаг
- E. Шилийн голын чуулган, Зуу-Удын чуулган

44. Дараах түүхэн зүтгэлтнүүдийн хэн нь Зүүн хүрээний нууц бүлгэмд багтаж байгаагүй вэ? **(1 оноо)**

- A. М.Дугаржав
- B. Д.Сүхбаатар
- C. Д.Догсом
- D. Д.Чагдаржав
- E. С.Данзан

45. Алс Дорнодын Бүгд Найрамдах улсын Троицковсавск тосгонд Оросын харьяат хүмүүс, Монголын улс төрийн зүтгэлтнүүд нийлэн хуралдаж Монголын улс төрийн байдлыг хэлэлцжээ. Энэ хурал хэзээ болсон бэ? **(1 оноо)**

- A. 1919 оны 2 сарын 4-6
- B. 1921 оны 6 сарын 22-25
- C. 1921 оны 3 сарын 1-3
- D. 1920 оны 1 сарын 18-25
- E. 1921 оны 3 сарын 18

46. Ардын засгийн газраас Богд хааны эрх хэмжээг ялган зааж өгсөн баримт бичиг аль нь вэ? **(2 оноо)**

- A. Тангаргийн гэрээ
- B. Тангаргийн бичиг
- C. Шашин, Төрийн нууц дүрэм
- D. Их шавийн захиргааны дүрэм
- E. Хэмжээт эрхт хаант төрийн гэрээ

47. Их хэлмэгдүүлэлт буюу хамгийн богино хугацаанд хамгийн олон хүнийг барьж хороосон оргил үе хэдээс хэдэн онд үргэлжилсэн бэ? **(2 оноо)**

- A. 1921-1924 он
- B. 1937-1939 он
- C. 1935-1937 он
- D. 1924-1928 он
- E. 1932-1934 он

48. 1939 оны Халх голын дайнд Монгол-Зөвлөлтийн цэргийг командлагчаар хэн ажилласан бэ? **(1 оноо)**

- A. Г.Жуков
- B. Ю.Цэдэнбал
- C. Г.Бумцэнд
- D. Л.Дандар
- E. М.П.Яковлев



49. “Чойбалсангийн үндсэн хууль” гэж оны үндсэн хуулийг нэрлэдэг. Нөхнө үү? **(1 оноо)**
A. 1992 B. 1924 C. 1960 D. 1945 E. 1940
50. Монгол улсын тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал асуулга хэдэн онд болсон бэ? **(1 оноо)**
A. 1989 он B. 1961 он C. 1960 он D. 1945 он E. 1992 он
51. 1961 онд байгуулсан Шинжлэх ухааны төв байгууллагыг хэрхэн нэрлэсэн бэ? **(1 оноо)**
A. Судар бичгийн хүрээлэн B. Шинжлэх Ухааны Хүрээлэн
C. Шинжлэх Ухааны Төв D. Шинжлэх Ухааны төв хүрээлэн
E. Шинжлэх Ухааны Академи
52. Монгол Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах үйлдвэр аль нь вэ? **(1 оноо)**
A. Шарын голын нүүрсний уурхай B. Хөтөлийн цемент шохойн үйлдвэр
C. Эрдэнэтийн зэс молибдений үйлдвэр D. Багануурын нүүрсний уурхай
E. Шивээ Овоогийн нүүрсний уурхай
53. Монгол улсын анхны дэд ерөнхийлөгч аль нь вэ? **(1 оноо)**
A. С.Зориг B. П.Очирбат
C. Ж.Батмөнх D. М.Энхсайхан E. Р.Гончигдорж
54. Ховдын багшийн дээд сургуулийн багш оюутнууд хэдэн оны хэдэн сарын хэдний өдөр ардчилсан өөрчлөлтөд уриалсан жагсаал зохион байгуулсан бэ? **(2 оноо)**
A. 1989 оны 12 сарын 7 B. 1989 оны 12 сарын 10
C. 1990 оны 3 сарын 7 D. 1991 оны 11 сарын 27
E. 1992 оны 1 сарын 13
55. Өмч хувьчлалын эрхийн бичиг цэнхэр ягаан тасалбарыг хэдэн онд гаргасан бэ? **(1 оноо)**
A. 1990 он B. 1991 он C. 1992 он D. 1993 он E. 1994 он
56. 1990-ээд оноос Монгол улсын мал сүргийг тоо толгой өссөны гол учир шалтгаан аль нь вэ? **(2 оноо)**
A. Малын халдварт өвчин гарахаа больсон учраас
B. Малыг улсынх болгож нэгдсэн зохион байгуулалтад оруулсных
C. Малын үүлдэр угсааг жил бүр сайжруулж байснаас
D. Малыг хувьчилсаны үр дүн
E. Зудгүй өнтэй өвөл олон байснаас



ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР**Санамж:**

а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү?

б. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Ураг төрлийн байгууллын үеийн 5 том соёлыг холбогдох дурсгалтай нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|-------------------|-----------------|
| 1. Бууц суурин | a. Ишгэн толгой |
| 2. Хөшөө чулуу | b. Цагаан агуй |
| 3. Хадны зураг | c. Хүрэл дуулга |
| 4. Булш, оршуулга | d. Норовлин уул |
| 5. Түүвэр олдвор | e. Уушгийн өвөр |

2.2. Монгол нутаг дахь эртний улсуудын хаадын төр барьсан он цагийг зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|-------------------|-------------------------|
| 1. Лаошань шаньюй | a. 691 – 716 он |
| 2. Таньшихуай | b. 156 – 181 он |
| 3. Шэлүнь хаан | c. 407 – 410 он |
| 4. Мокунчур хаан | d. 744 - 747 он |
| 5. Мого хаан | e. НТӨ 174 – НТӨ 161 он |

2.3. Монголын хаадыг оны цолтой нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|-------------------|----------------|
| 1. Төгстөмөр хаан | a. Засагт хаан |
| 2. Тогтобуха хаан | b. Гүдэн хаан |
| 3. Батмөнх хаан | c. Тайсун хаан |
| 4. Дарайсун хаан | d. Даян хаан |
| 5. Түмэн хаан | e. Усгал хаан |

2.4. 1921 онд байгуулагдсан Ардын засгийн газрын яамдыг сайдуудтай нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|----------------|-----------------|
| 1. Дотоод яам | a. С.Данзан |
| 2. Гадаад яам | b. Д.Сүхбаатар |
| 3. Сангийн яам | c. Г.Магсаржав |
| 4. Шүүх яам | d. Д.Бодоо |
| 5. Цэргийн яам | e. Д.Пунцагдорж |

